

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГТААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 41 (3205) 1974 оны 5 дугаар сарын 27 ДАВАА

МАЛЫН ХОРОГДОЛ БАГАСГАХ КОМИСС

Малын зүй бусын хорогдлыг багасгах ажил эрхэлсэн аймаг, сумдын комиссууд нь малын хорогдлыг багасгахтай холбогдсон зохион байгуулалтын асуудлыг төвлөрүүлж, өдөр тутам шуурхай арга хэмжээ авч, малыг элдэв үхэл хорогдлоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг хангуулах үүрэгтэй.

Аймаг, сумдын комиссууд сүүлийн жилүүдийн малын хорогдолд судалгаа дүгнэлт хийж, 4 төрлийн хорогдлыг дунджаар энэ онд 45—50 хувь багасгах зорилт тавьж, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллага малын хорогдлыг багасгах зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч малын өвөлжилт, хаваржилтыг сайжруулах, сууриудыг өвс, тэжээл, хужир усаар хангах талаар нилээд ажил зохиожээ.

Баянцогт, Угтаал, Борнуур, Баянцагаан зэрэг сумдын комиссууд, бригад сууриудад тодорхой ажил зохиож, өвчтэй ба ядарсан малыг ялган, эмчилгээ тэжээлийн цэгүүдэд хамарч, сэхээн эдлгээрүүлж байгаагаас төд ба бусад малын хорогдлыг өнгөрсөн оныхоос эрс багасгах боломжийг олж байна.

Гэвч орон нутгийн нилээд комиссуудын ажил тодорхой биш, малын хорогдлыг багасгах талаар бригад, сууриудад үр нөлөөтэй ажил зохиохгүй зөвхөн төлөвлөгөө зохиосноос цааш хэтэрч чадаагүй байна.

Одоогийн байдлаар Баянзүрх, Заамар, Лүн сумдын том малын хорогдол, Бүрэн, Жаргалант, Эрдэнэ сумдын төлийн хорогдол өнгөрсөн оны энэ үеийнхээс илүү байгаагийн дээр ялангуяа Заамар, Баяндэлгэр, Бүрэн сумдын төлийн хорогдол үлэмж их байна.

Төд ба том мал хорогдож байгаа нь малчдын арга ажиллагаа, нэгдэл САА-н зүгээс авах зохион байгуулалтын ажил хангалтгүйгээс голлон шалтгаалж бай-

Зарим сумын комисс түүний гишүүд бригад суурь, тогтвортой ажиллаж, хариуцуулсан сууриараа тогтмол явж туслахгүй байгаагийн дээр малчдын хариуцлага, сахилга бат сулаас малыг өл хоол, хужир, усаар гачигдуулах, чононд идүүлэх, нялх төлийг бүтээж үхүүлэх зэргээр хохирол учруулсан баримт цөөнгүй байна.

Эрдэнэ сум-нэгдлийн «Нарст» бригадын хоньчин Ц. Дарамбазар маллагаа, арчилгааны муугаас 112 хурга, 31 хонь үхүүлж, 81 хонь дутаажээ.

Ийм байдалд орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллага, малын хорогдлыг багасгах комиссууд дүгнэлт хийж, ялангуяа малын хорогдолтой тэмцэх комиссын үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх хэрэгтэй.

Малын хорогдлыг багасгах комиссууд бол хорогдол гаргахгүй байхад бүх нийтийн хүч анхаарлыг чиглүүлж, нэгч мал үхүүлэхгүй байх нөхцөлийг хангуулж байвал зохино.

Малын хорогдлыг багасгах комиссууд нь Ардын хянан шалгах байгууллага, АДХ-ын байнгын комисстэй хамтарч мал аж-ахуйн мэргэжилтний хүчийг ашиглан мал аж-ахуйн бүхий л ажиллагаанд хяналт шалгалтыг хийж зохион байгуулалтын шуурхай арга хэмжээ авч байх нь зүйтэй.

Комиссын хурлыг тогтмол хийх, гаргасан шийдвэр, баталсан төлөвлөгөөнийхөө биелэлтийг дүгнэх, мал аж-ахуйн мэргэжилтэн, бригад, фермийн илтгэл сонсголыг авах, гишүүддээ тодорхой ажил, бригад суурь хариуцуулах, малын хорогдолгүй суурь, малчдын туршлагыг дэлгэрүүлэх ажил зохиох хэрэгтэй.

Мөн малын эмч, малчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, ялангуяа ажиллагаа султай юм уу олон мал хорогдуулсан малчдыг хамт олноор нь хэлэлцүүлж дутагдлыг нь ухамсардуулж байх нь зүйтэй.

Урин дулаан болж, ногоонд залгаснаар тайвширч санаа амрах явдалтай шийдвэртэй тэмцэл хийж, малыг ямар нэг шалтгаанаар үхэж хорогдох явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг яаралтай авч байх явдал чухал.

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 22-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 79,5 хувь буюу 504,4 мянга нь төлөж гарсан төлийн 98,3 хувь буюу 500,9 мянга нь бойжиж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 23,9 хувь буюу 96,9 мянган төл илүү бойжиж байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүдбэл:

Сумдын нэр	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баянцагаан	99,9	1
Баян	99,8	2
Угтаал	99,7	3
Баянжаргалан	99,5	4
Баянцогт	99,5	5
Сэргэлэн	99,4	6
Эрдэнэсант	99,3	7
Дэлгэрхаан	99,3	8
Алтанбулаг	99,2	9
Өндөрширээт	99,2	10
Лүн	99,2	11
Баянчандмань	99,2	12
Баянзүрх	99,1	13
Баян-өнжүүл	99,0	14
Мөнгөнморьт	98,9	15
Батсүмбэр	97,8	16
Борнуур	97,7	17
Бүрэн	96,8	18
Эрдэнэ	95,6	19
Жаргалант	95,4	20
Баяндэлгэр	95,0	21
Заамар	93,4	22

Статистикийн товчоо

ШАГНАЛ АВАВ

МАХН-ын III их хурал, Улсын Хороо, МХЗЭ-ийн БНМАУ-ыг тунхагласны Төв Хорооны 1 дүгээр 50 жилийн ойг угтан зэргийн диплом, 1000 төгрөгөөр шагнагдлаа.

БНМАУ-ын техник мэргэжлийн сургуулиудын суралчдын дунд явагдсан урлагийн үзлэгт Баянчандмань сумын ТМС амжилттай оролцож, сургуулиараа 1 дүгээр байр эзлэн, МУЭ-ийн Төв Зөвлөл, Хөдөлмөр Цалин Хөлсний тус сургуулийн 12 бүжигчний бүжиглэсэн «Атрын залуус» бүжиг, үндэсний найрал хөгжмийн чуулга уг үзлэгт 1 дүгээр байр эзлэв.

Д. ДОРЖСҮРЭН

ТАРИАЛАЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ

Аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 22-ны байдлаар 110,0 мянган га-д үрлэлт хийж, төлөвлөгөөний 92,1 хувийг биелүүлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0,3 хувиар илүү байна.

Үр тарианы тариалалтын төлөвлөгөөг 101,0, төмсний 70,8, хүнсний ногооны 30,9, тэжээлийн ургамлын 25,9 хувийг тус тус биелүүлээд байна.

Тариалалтын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар үзүүлбэл: (Хувиар)

Сумд	Нийт тал- бай	үү- нээс үр тари-
Алтанбулаг	31,6	101,6
Батсүмбэр	77,1	100,0
Баян	29,6	100,0
Баян-өнжүүл	29,5	100,0
Баяндэлгэр	78,0	195,7
Баянжаргалан	24,6	100,0
Баянзүрх	55,6	-
Баянцагаан	19,0	100,0
Баянцогт	94,4	100,1
Борнуур	73,3	100,3
Бүрэн	33,4	100,0
Дэлгэрхаан	0	-
Жаргалант	95,8	98,1
Заамар	67,3	104,3
Лүн	82,3	126,5
Мөнгөнморьт	24,7	100,0
Өндөрширээт	91,6	101,0
Сэргэлэн	15,9	-
Угтаал	101,5	101,5
Эрдэнэ	58,3	100,0
Эрдэнэсант	-	-
ТАА	100,0	102,1
Архуст ТАА	102,2	100,1

Статистикийн товчоо

АЙМГИЙН НАМЫН XVI БАГА ХУРЛЫН ӨМНӨ

НАМЫН АЖИЛТНУУДЫН ТУРШЛАГА СУРГУУЛЬ

Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань сумдын намын нийт сонгуульны туршлага сургууль Жаргалантын САА-н төвд болов.

Туршлага сургуулиар НАШБ-ын нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохиож байгаа ажлаар үзэсгэлэн байгуулж, Жаргалантын САА-н намын анхан шатны 6 үүрийн ажлыг хамтран шалгаж зааварлав.

Дараа нь семинар болж, хөдөлмөрийн хамт олныг идэвхжүүлэн хүмүүжүүлж байгаа аргаасаа Жаргалантын САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Н. Дашням, СХ-ийн хөдөлгөөн ба олон жилийн

тооцоот үүрэг авахуулах ажлыг хэрхэн удирдаж байгаа тухай Батсүмбэрийн САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Г. Хаянхярваа, аж-ахуйг намын аргаар удирдаж байгаа туршлагаасаа Борнуурын САА-н намын хорооны нарийн бичгийн дарга Д. Чүлтэм, Намын сонгуультай ажилладаг аргаасаа Баянчандмань намын хорооны нарийн бичгийн дарга Цог-бадрах, тогтоолыг хувийн хэрэгжүүлж тооцон дүгнэдэг тухайгаа Борнуурын САА-н намын хорооны зааварлагч Н. Ганхүү нар ярих.

Дараа нь 4 сумын намын нийт сонгуульны зөвлөлгөөн болж «НАШБ-

уудын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөн, аймгийн намын VI бүгд хурлын шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх» гэсэн сонголт хэлэлцэж өөрсдийн ажилд байгаа туршлага, оршиж байгаа дутагдал, түүнийг засч сайжруулах талаар тодорхой ярилцлаа.

Ингэж намын байгууллагууд намын ажлын дайчин чадвар үр нөлөөг дээшлүүлэх талаар хамтран ажиллаж байгаа нь НАШБ-уудын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улам эрчимжүүлэх явдал чухал болж байна.

М. САМДАН

АЙМГИЙН УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГИЙН VI БАГА ХУРАЛ

Саяхан аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийн VI бага хурал Зуунод хотод болж аймгийн УЗН-ийн хорооны дарга Б.Галсандорж аймгийн УЗН-ийн ажлын тайлан илтгэлийг тавьж хэлэлцүүлэв.

Анхан шатны 130 салбар хороо, үүрт 8200 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгэсэн аймгийн УЗНХ нам, засгаас ард түмний эрүүд энхийг хамгаалах талаар гаргасан тогтоол шийдвэр, МУЗН-ээс лэвшүүлсэн ээлжит зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулалтын ажлаа чиглүүлэн ажилласан байна. Аймгийн УЗН-ийн хороо гаргасан тогтоол, шийдвэр, уралдааны болзолноо биелэлтэд 4 удаа 70 гаруй салбар, хороо, үүрүүдэд шалгалт хийсний гадна хөдөлмөрдчийн хөдөлмөрлөх нөхцөл, ахуйн соёлжилт, эх ялхсын эрүүл мэндийг хамгаалахтай холбогдуулж ЭХГ болон бусад байгууллагуудтай хамтарсан үзлэгийг төв, хөдөөд 20 шахам удаа хийжээ.

Эмнэлэг гэгээрлийн суртал нэвтрүүлгийг төрөл бүрийн дугуйлан, хичээл, лекц зэрэг олон хэлбэрээр явуулж 7500—гаад хүнд ариун цэврийн анхны мэдэгдэхүүн, 3000 гаруй сурагчдад ариун цэврийн хамгаалалтанд бэлхэн хичээлийн программаар, ариун цэврийн идэвхтэн бэлтгэх дугуйлангаар 381 хүн, иргэний хамгаалалтын ариун цэв-

рийн нөхөрлөлийн программаар 680 хүн тус тус төгсгөж гэрчилгээ үнэмлэх олгожээ.

Үүний үрээр улаан загалмайн идэвхтэн гишүүд 2000 шахам хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, 9500 гаруй өвчтөнд гэрээр нь үйлчилэн 10 мянга гаруй төгрөгийн эм бараа бордуулжээ.

Мөн эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилгыг жил бүр 20 мянган хүнд урьдчилан сэргийлэх вакцины 7000 хүүхдэд уулгахад УЗН идэвхтэн гишүүд, эмнэлгийн байгууллагат туслаж төлөвлөгөөг давуулан биелүүлж ирсэн байна. Жирэмсэн эхчүүд болон 0—1 насны хүүхдийн эмнэлгийн давхар хяналтанд авах хүүхдийн байгууллагын ажилд биечлэн тусалсны үрээр хүүхдийн нас бараалт 1973 онд 5 хувиар буурч ясли, цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн эрүүл ахуйн нөхцөл, хоол унд, арчилгаа, үйлчилгээ, ариун цэвэр сайжирлаа.

Гэвч улаан загалмайн нийгэмлэгийн анхан шатны байгууллагуудаас хөдөлмөрдчийн дунд зохиох эмнэлгийн суртал нэвтрүүлэг, ахуйд соёл нэвтрүүлэх, байгаль орчныг хамгаалах, иргэний хамгаалалтын мэргэжил эзэмшүүлэлт зэрэг ажлууд шаардлагын хэмжээнд биш байгааг бага хурал тэмдэглэв.

Аймгийн УЗН-ийн VI бага хуралд төв, хөдөө-

гийн УЗН-ийн салбар хороо, үүрийн дарга, төлөөлөгчдөөс гадна аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга Х. Билгээ, аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Е. Банзрагч нар оролцлоо.

Тавигдсан илтгэлтэй холбогдуулж их эмч Т. Мамар, Сонины үйлдвэрийн УЗ үүрийн дарга С. Цэгмэд, Баян-өнжүүлийн их эмч Ж. Бужгар нарын 20-иод хүн үг хэлэв.

Мөн МУЗН-ийн гүйцэтгэх хорооны ажилтан Цэвээн оролцож дэлгэрэнгүй үг хэллээ.

Бага хурлаас аймгийн УЗН-ийн ажлыг цаашид улам сайжруулах талаар тодорхой заалт бүхий тогтоол гарлаа.

Бага хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж аймгийн УЗН-ийн бүгд хурлыг 41 гишүүнтэйгээр сонгож баталсны гадна МУЗН-ийн V их хуралд очих төлөөлөгчөөр их эмч Ж. Доржготов, «Анхдугаар таван жил» сонинны үйлдвэрийн дэвтэрлэгч Л. Гэрэлмаа, Заамар сумын түргэн тусламжийн жооноч Жамсран нарын 8 хүнийг сонгодоо.

Дараа нь аймгийн УЗН-ийн анхдугаар бүгд хурал болж аймгийн УЗН-ийн хорооны тэргүүлэгчдийг 9 хүний бүрэлдэхүүнтэй сонгож, аймгийн УЗН-ийн хорооны даргаар Б. Галсандоржийг, орлогч даргаар Д. Намар нарыг сонгож батлав.

Ш. ЦЭРЭНДОО

ХҮҮХДИЙН ТӨЛӨВ ФОНДОД

Өнгөрөгч Бямба, Ням гаригийн субботникоор аймгийн Авто тээврийн XIII баазан засварчил, албанхаагчид гаражшаркийн цэвэрлэгээ, авто машин чиргүүлийн засвар үйлчилгээ хийж ГАЗ—51, ГАЗ—53, ЗИЛ—130 машины мотор дөрвийг бүрэн задаргаа хийж засварлан ГАЗ—53, ЗИЛ—130 машины блок тус бүр 1-ийг гагнаа, хадаж засварлан 6 машиныг засварлаас гаргаснаар авто машин чиргүүлийн техникийн 63-

лэн байх коэффициент 0,812—1,0-д хүрчээ.

Мөн ажилгүй байсан 0,5 тоннны даацтай цахилгаан талийг засварлан бэлэн болгосон ба дархан З. Бат-очир, тагорчин Г. Төмөрчөлөр, гагнуурчин Н. Даваа, аккумуляторчин Д. Батмөнх нар 14х22-ын дорцоов, түлхүүр, агрегат засварлах тэрэг зэргийг хаягдал ашиглан хийснээр 948 төгрөгийн хэмнэлт орууллаа.

С. ОТГОН

ЗХУ—Д СОЦИАЛИСТ УРАЛДААН ӨРНӨЖ БАЙНА

ЗХУКН-ын Төв Хороо, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөл, Бүх Холбоотын УЗ-ийн Төв Зөвлөл, БХЛКЗЭ-ийн Төв Хорооноос 1974 оны улс ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг хугацаанаас нь өмнө биелүүлэхийн тулд аж үйлдвэр, барилга-тээвэр, ХАА-н байгууллагын ажилчин, албан хаагчдын дунд социалист уралдаан өрнүүлэх тогтоол гаргасан билээ.

Уг тогтоолд социалист уралдаанд өндөр амжилт гаргасан хамт олныг шагнаж урамшуулахын тул ЗХУКН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл, Бүх Холбоотын УЗ-ийн Төв Зөвлөл, Комсомолын Төв Хорооны шилжих 750 улаан туг, диплом, 180 мянган рублийн шагнал тогтоожээ.

Уралдаанд байр эзэлсэн хот, районыг шагнахын тулд диплом, 10—40 мянган рублийн мөнгөн шагнал бүхий шилжих 100 улаан туг бий болгов.

Өндөр бүтээлтэй шинэ техник бий болгож үйлдвэрлэлийн техникийн түвшинг дээшлүүлж бүтээгдэхүүний чанарыг сайжруулан шаардлагатай ба-

рилгыг хугацаанаас нь өмнө ашиглалтанд оруулж 5 жилийн төлөвлөгөөг биелүүлж тодорхой амжилт гаргасан үйлдвэр, барилга, тээврийн байгууллагууд, бригад, хэсгийн засгийн газрын шагналд тодорхойлж байх юм. Уралдаанд түрүүлэгчдэд олгох «1974 оны социалист уралдаанд түрүүлэгч», «IX таван жилийн гавшгай» тэмдгүүдийг бий болгов. Бас 1974 онд мал аж ахуй, газар тариалангийн ба улсад нийлүүлэх ХАА-н бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхээр социалист уралдаан өрнүүлэхээр шийдвэрлэжээ.

Мөн гарамгай амжилт гаргасан хамтраал, САА, ХАА-н байгууллагуудад шилжин явах улаан туг, диплом, мөнгөн шагнал олгож байхаар тогтоожээ.

Түүнчлэн социалист уралдаанд шалгарсан хамтралчид, САА-н ажилчил, инженер техникийн ажилтнуудыг «1974 оны социалист уралдаанд түрүүлэгч» тэмдгээр шагнаж байхаас гадна онцгой үр бүтээлтэй гаргасан ХАА-н байгууллага, хүмүүсийг улсын одон медалиар шагнах юм.

Ч. БУЯН-ОЧИР

ТӨЛЧДИЙН АМЖИЛТ

Малын төл хүлээн авч бойжуулах ажилд Баянцагаан сумын малчид хөдөлмөрчид урьд жилүүдээс илүү амжилт олж байна.

Одоогийн байдлаар төллөх бүх малын 80,4 хувь буюу 37411 мал төлөж, 38568 төл хүлээн авч 1100 гаруй ихэр

төлтэй байна. Тус сумын Өлзийт, Баянайраг, Гурван-түрүү, Алтат бригадууд 108—400 гаруй ихэр төлтэй, гарсан төл нь бүрэн бойжиж байгаагийн дотор Гурван-түрүү, Алтат бригадууд төл бойжилтоор тэргүүлж явна.

Д. БАНЗРАГЧ

МАЛЫН ТАРГА

Малын тарга гэдэг бол цэвэр орлого буюу малын биед агуулагдаж яваа эдийн засгийн онцгой чухал үзүүлэлт мөн.

Мал бүрт тарга хүч сайн авахуулах нь нэг талаас авах мах болон буцад ашиг шимийн хэмжээг нэмэгдүүлэх замаар улс ардын аж ахуйн чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх асар их ач холбогдолтой юм.

Тарган мал ашиг шим, үр төлөөр сайн, үс ноос нь хүртэл зунгаж сайтай, өтгөн шигүү, урт ургаж, арьс шир нь зузаан, хүнд байдаг.

Малд зузаан тарга авахуулахын тулд алс хол олон дахин нүүхдээ байгаа биш хамгийн гол нь төрөл бүрийн малд бэлчээрийг зөв тохируулж

аль сайн нутгийг сонгон авч түүнийг эрэмбэ дараатай зөв ашиглах явдал юм.

Үүнийг анхаарч бэлчээрийн өвс ногоо сорлогдон гишгэгдэж ногооны өнгө муудмагц бэлчээрийг сэлгэнэ.

Зуны бэлчээрийг үндсэнд нь бүрхэг сэрүүн, хурц нартай, бороотойд ашиглах зэргээр хувааж бүх зүгийн бэлчээрийг дээрхи байдалд зохицуулан өглөө, оройн сэрүүн, өдрийн халуунд ашиглах гэх мэтээр зааг тогтооно.

Зун ногоо элбэг байна гэж санаа тайвшран мал таргалуулах ажлыг урсгал нь тавьж болохгүй.

Малчин хүн юуны урьд хариуцсан малынхаа дундаж жинг хичнээн кг-д хүргэж, нийгэмдээ болон

өөртөө ямар орлоготой болохыг сайтар ойлгосон байвал зохино.

Нөгөө талаар малын төрөл, нас, хүйсээр нь малын тарга хүч авах чадварыг орон нутгийн онцлогт тохируулан тогтоож аль суурь хэзээ хаана буусан байхыг графикаар нарийвчлан тогтоон өгч мөрдүүлэх ёстой.

Мал таргалуулах ажилд тэргүүний арга туршлага нэвтрүүлэх нь чухал.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б. Агваа хавар цас ханзарч, аж нүдлэж эхэлмэгц яргуй хамгийн түрүүнд ургадаг бэлчээрийг сонгон нүүдэл хийж хар мах авахуулдаг байна. Ингээд ногоо жигд ургаж гүйцмэгц хотгүй оторт шилжин өдөр дунд 2 цаг хиртэй бэлчээрт нь амраагаад бусад бүх хугацаанд идэшлүүлэн бэлчээрийг ойр ойрхон сэл-

гэж өдөрт 2 удаа усалдаг байна.

Хонь, ямааг шүүслэг нийл ногоонд цагтахын тулд өглөө, оройн сэрүүнийг ашиглан наранд хавраагүй ногоо идүүлэхийг чухалчилдаг байна.

Дэндүү ээрч хариулбал гүйцэт цадалгүй хэвтэх учир задгайдуухан тааваар нь хариулж хэд гурваараа хорж зогсоол зориуд тараадаг байна.

Хонь, ямааг сүргийг өглөө бэлчээх, өдөр харуулах, орой хотлуулахдаа түүний гишгэгдлийг ямагт өвс ногоо зулгааж байхаар тааруулж ширүүн явуулахыг цээрлэвэл зохино.

Уулархаг газар бол хонь ямааг өглөөгүүр уулын ар царам, хормойн сүүдрийн агшилтыг дагуулан, тал газар бол өглөөний нар тосгуулан бэлчээгээд нар хүчтэй

шарах үед эргүүлэн толгойг нь биеэр нь нарнаас хаах замаар идэшлүүлэх нь ашигтай.

Зуны цагт саалийн ажлыг малдаа тарга хүч авахуулахтай нягт хослон саалийн ферм, суурьт байх малын тоог аль болохоор цөөн байлгаж нутаг бэлчээрээ ойр ойрхон сэлгэж байвал зохино.

Бүх төрлийн малд тарга хүч сайн авахуулах ажлыг сум-нэгдэл, САА-н нам, улс, олон нийт, ХАА-н байгууллага, мал аж ахуйн мэргэжилтнүүд сайн зохион байгуулж энэ ажлын эдийн засгийн ач холбогдлыг малчдад сайтар ойлгуулан зун, намрын отор нүүдлийг сайн хийх, ялангуяа мал ногоолуулах ажилд онцгой анхаарал тавьж ажиллах явдал чухал байна.

М. САМДАН

Бүх ард түмний социалист уралдаан

СОЦИАЛИСТ УРАЛДААНЫ ЛЕНИНЧ ЗАРЧИМ

Социалист уралдаан социалист хөдөлмөрийн хөдөлгөөнийг өрнүүлэхэд уралдаан зохиох Ленинч зарчмыг судалж үйл ажиллагааныхаа удирдлага болгох нь онол практикийн чухал ач холбогдолтой юм.

Уралдааныг ил зохиох зарчим

В. И. Ленин «социалист уралдааны явц, үр дүнг өргөн сурталчилж нийтэд мэдээлж байх нь уралдааныг зөв зохион байгуулах анхдагч нөхцөл» гэж үзсэн юм.

Энэ зарчмын гол зорилго нь уралдаанд хошуучилсан тэргүүний хүмүүс, үйлдвэрлэлийн хамт олныг тодруулан, гаргаж нийтэд өргөн сурталчлахад оршино.

Уралдааныг ил зохиох хэлбэр нь асар олон юм. Үүнээс хамгийн ашигтай нь хэвлэл, радио, сум байгууллага, бригадын сар удирдлагийн хөдөлгөөл, ухуулга, лекц, хөдөлмөрдийн гэгээрлийн хурал, зөвлөлгөөн, уралдааны үзүүлэлтийн самбар, зурагт хуудсыг ашиглан сурталчлах явдал юм.

Ялангуяа сар, улирал, жилээр ажлаа нэгтгэн дүгнэж, дараа жил, улиралд хийж гүйцэтгэх ажлын гол үндсэн зорилтыг дэвшүүлсэн илтгэл ярианы сэдэв боловсруулж уралдааны үүрэг, төлөвлөгөөт ажлын явцыг тодоор сурталчлах нь чухал.

Үр дүнг харьцуулах зарчим

В. И. Ленин «Энэ зарчим нь тэргүүний хамт олон болон хүмүүсийн гаргасан амжилтыг бусад хоёрч яваа хэсгийнх нь ажлын үр дүнтэй харьцуулан үзэх боломжийг олгоно» гэжээ.

Энэ зарчим нь тэргүүний хүмүүс хамт олны амжилтыг бусад хоёрч яваа хэсгийнх нь ажлын үр дүнтэй буюу улс, аймгийн дундажтай харьцуулж үзнэ гэсэн хэрэг юм. Иймээс уралдааны

дүнг сар улирал жилээр дүгнэхдээ бусад суурь, бригад, тасаг, нэгдэл, САА-тай харьцуулан дүгнэлт хийж чухам юун дээр голлож анхаарах, тэргүүний байгууллага хүмүүсийн амжилтад хүрэх арга зам, боломжийг судалж ажилладаг болох явдал чухал юм.

Тэргүүний туршлага практик ажиллагаанд давтах зарчим

В. И. Ленин, энэ зарчмыг олон түмний бүтээлч идэвх санаачилгыг өрнүүлэхийн шийдвэрлэх нөхцөлийн нэг гэж үзэж түүнд онцгой анхаарал тавьж байжээ. Олон түмний бүтээлч идэвх санаачилга эрч хүч нь ажлын арга барил, түүний зохион байгуулалтад цаг ямагт шинэ зүйлийг буй болгож байдаг учир тэдгээрийг дэлгэрүүлэх явдал нийгмийг урагш хөгжүүлж социалист эдийн засгийн төлөвлөгөөг хангаж биелүүлэхэд түлхэц өгдөг байна. Иймд: Аливаа дэв-

шилттэй арга туршлагыг сонор соргоогоор ажиг, түүнийг нийтийн хүртээл болгох нь үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх нэг нөхцөл болно.

Харилцан туслалцах хамтач ажиллагааны зарчим

Энэ зарчим нь социалист уралдааны мөн чанараас урган гарсан юм.

Ажилд амжилт гаргасан ажилчин, малчин болон хөдөлмөрийн хамт олон, бусдыгаа илүү сайн ажиллуулахын тулд ажил төлөөрөө хоорондоо нөхдөө туслалж өөрсдийн арга туршлагаа эзэмшүүлдэг. Ингэж чадсан цагт л сая нийтээрээ амжилтад хүрдэг.

Бидний дунд хоцрогсод байх ёсгүй гэсэн лозун бол хөдөлмөрийн хамт олны гол зорилт болж байна.

Нийт нэгдэл, САА, үйлдвэр, албан газрын нам, захиргаа, олон нийтийн байгууллага, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, улсын аварга малчин, ногоочид, тракторч, комбайнчдын үлгэр дууриаллаар бусдыг

хүмүүжүүлэх, илгээлтийн ээдийг ахмад тэргүүний хүмүүсийг дагалдуулан ажиллуулж багш шавийн харилцаа тогтоож тэдний туршлагыг эзэмшүүлэхэд онцгой анхаарвал зохино.

Улсын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах, чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд социалист уралдааныг зохион байгуулах Ленинч зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлэх явдал чухал ач холбогдолтой юм.

Дээрх зарчмыг социалист уралдааныг удирдах ажлын практикт нэвтрүүлж, социалист уралдааныг үйлдвэрлэлийг удирдахад олон түмнийг татан оролцуулах гол хэлбэр, хөдөлмөрдийн коммунист хүмүүжлээр хүмүүжүүлэх шилдэг хэрэгсэл болгох явдал нам, улс, олон нийтийн байгууллагуудын удирдах ажилтан нарын гол зорилт мөн.

Б. СЭМБЭЭЖАВ

ЯВЦЫГ ЭРЧИМЖҮҮЛБЭ

Аймгийн соёлын байгууллагуудад 1974 онд социалист уралдааныг өрнөлт явц ямар байгаад тус сонинны редакци саяхан цуурхай үзлэг хийв.

Үзлэгийн дүнгээс үзэхэд соёлын ордон, дүрслэх урлагийн салбартай, кино театр, номын худалдаатай, нүүдлийн кино, номын сан, гэрэл зургийн салбартай тус тус хэлс уралдаанд үүрэг амлалт аваад ажиллаж байна.

Эдгээр газрууд уралдаанаа улирал, сараар дүгнэж шагнаж урамшуулдаг байна. Байгууллагуудын хоорондын уралдааныг саяхан дүгнэхэд улирлын төлөвлөгөөг 135,3 хувиар биелүүлсэн нүүдлийн кино 1 дүгээр байр эзэлж шилжин явах дарцаг, мөнгөн шагнал авч 2,3 дугаар байрт төлөвлөгөөгөө 129,9 хувиар биелүүлсэн кино театр, номын сан орсон байна.

Аймгийн кино театр, нүүдлийн киноны 28 цэг салбар, кино механикч монтажчин нараар уралдаанд үүрэг амлалт авахуулжээ. Аймгийн дүрслэх урлагийн салбар бүх ажилтан ажилчдаар оны эхэнд үүрэг амлалт авахуулж уралдааныг дүгнэх сурталчлах тооцоо талаар хэд хэдэн аятайхан арга хэрэглэж байна.

Дүрслэх урлагийн салбар, «Анхдугаар таван жил» сонинны үйлдвэрийн туршлагаар мандатын уралдаан өрнүүлж тусгай болзол гаргаж сар бүр дүгнэж байна.

Мөн уралдааныг дүгнэж хэлэлцэх, шагнаж урамшуулах ажлыг сар бүрийн дөрөвдүгээр 7 хоногийн пүрэв гариг бүр хийдэг болжээ.

Тус салбар уралдааныг дүгнэхдээ бүтээгдэхүүний чанарыг онцлон анхаарч бүтээгдэхүүн болгонд чанар тогтоож протокол хөтөлдөг ажээ. Эднийх ажилчдын дунд 100 давсан хувьтан болох хөдөлгөөнийг өрнүүлж байна.

Мөн ажилтан ажилчдын ажлын цаг ашиглалтыг нилээд нарийн бүртгэн тооцоолдог болсны дүнд хүмүүс уралдаанд авсан үүрэг амлалтын биелэл-

Манай сонинны цуурхай үзлэг

тийг сайн мэддэг болжээ.

Энэ бүхний дүнд ажилтан ажилчдын хөдөлмөрийн идэвхи тус салбарт өрнөж, улирлын төлөвлөгөөг 102,5, уралдаанд авсан үүргээ 101,1 хувь биелүүлж салбарын дүнгээр бүтээгдэхүүнийхээ 85,5 хувийг нэгдүгээр зэрэгт тушаажээ.

Тус салбар одоогийн байдлаар хагас жилийн төлөвлөгөөг 1 сарын өмнө биелүүлэх боломж олоод байна. Гэтэл нэгдүгээр улирлын төлөвлөгөөг аймгийн соёлын ордон 43,6—56,5, гэрэл зураг 8, ОНС музей 47,9 хувиар тасалдуулсан байна. Энэ нь төлөвлөгөө, уралдааны үүрэг амлалтанд хяналт тавьж

тооцож үзэж дүгнэх, цаг тухайд нь шалгаж зааварлах явдал хаа хаанаа дутагдахтайгаас болжээ.

Ер нь аймгийн соёлын ордны нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас уралдаанд оны эхнээс үүрэг амлалт авахуулах, сурталчлах, дүгнэх ажил тун хангалтгүй байна. Тус ордны 40 гаруй хүнээс бараг тал хувь нь уралдаанд өдий болтол үүрэг амлалт аваагүй байна.

Ингэж уралдааныг, хүмүүсийг хүмүүжүүлэн хамт олныг идэвхжүүлэх хөшүүрэг болгон өрнүүлээгүйгээс зарим жүжигчид, багш нарын ажлын цаг ашиглалт муу, хүмүүжил доголдолтой, зарим уран бүтээлийн үзэл суртлын хэмжээ шаардлагын хэмжээнд хүрээгүй байна. Мэргэжлийн зарим багш нарын дунд ажлын цагаар архи ууж, цагтаа ирэхгүй жүжигчдийг хүлээгдүүллэг дутагдах үзэгдэж байна.

Багш жүжигчдийн үүргийн биелэлтийг улирал тутам дүгнэх ёстой боловч одоо болтол дүгнэсэнгүй. Эдгээр байгууллагуудын заримы нь төлөвлөгөө тасарч амлалт үүргийн биелэлт жигд биш байхад аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтсээс төлөвлөгөөний биелэлт уралдааны амлалт ямар байгаад санаа тавихгүй, хөдөөгийн клуб, улаан булан, нүүдлийн киноны ажлыг шалган зааварлах ажил тун хангалтгүй, он гарсаар дөнгөж 3 газрын ажлыг шалган зааварласан төдий байна. Эдгээр дутагдалдаа дүгнэлт хийж социа-

лист уралдааны явцыг улам эрчимжүүлэх нь соёлын байгууллагуудын чухал зорилт мөн. Үүний тулд уралдааныг дүгнэхдээ төлөвлөгөөт үзүүлэлтийн зэрэгцээ жүжигчин, зурагчин, зураач нарын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх уран бүтээлийн чанар чансааг сайжруулах, тэдний сахилга бат харилцан үндэснээр өндөржүүлэхтэй холбогдсон үзүүлэлтүүдийг голчлон анхаарч дүгнэж байвал зохино.

Манай сурвалжлагч

Л. ГУНГААБУУ

Д. БАДАРЧ



Аймгийн Дүрслэх урлагийн салбарын торгон хэвлэлийн тасгийн ажилчин Ч. Пунсандулам бүх ард түмний социалист уралдааны жил—1974 онд хагас жилийн төлөвлөгөө болон уралдаанд авсан үүргээ нэг сарын өмнө 100-гаас дээш хувиар биелүүлж хамт олноо хошуучилж явна. ЗУРАГ ДЭЭР: Торгон хэвлэлийн тасгийн хэвлэгч Ч. Пунсандулам байрын бичиг хэвлэж байгаа нь.

Л. ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг



Хөдөлмөрчдийн хууль Зүйн мэдлэгт

ГЭР БҮЛИЙН ХУУЛЬ

БНМАУ-ын Ардын Их Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн VII чуулган БНМАУ-ын гэр бүлийн хуулийг шинэчлэн баталсан билээ.

Гэр бүлийн шинэ хууль нь манай нийгмийн үндэс болсон гэр бүлийн амьдралын хамгийн нарийн төвөгтэй ээдрээтэй асуудлыг тал бүрээс нь гүн гүнзгий боловсруулсан эрхийн чухал хэм хэмжээ юм.

Гэр бүлийн хууль тогтоомж нь социалист гэр бүлийг бэхжүүлэх, гэр ахуйн харилцаанд эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж нийгмийн гэр бүлийн харилцааг улам боловсронгуй болгоход оршиж байна.

БНМАУ-ын гэр бүлийн хуулийн 1 дүгээр зүйлд «БНМАУ-ын гэр бүлийн хуулийн зорилго нь коммунист ёс суртахууны зарчмаар үүссэн гэр бү-

лийг дэмжин бэхжүүлэх эцэг, эх, үр хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүний эрх ашгийг хамгаалах, гэрлэгсдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлагыг дээшлүүлэн гэр бүл, гэр ахуйн харилцаанд үлдсэн аливаа хоцрогдмол дадал заншлыг арилгахад оршино» гэжээ.

Гэр бүлийн хуулиар гэрлэлт, гэр бүлийн нэн чухал асуудлыг зохицуулдаг билээ. Гэр бүлийн хууднаар гэрлэх, гэрлэснээ цуцлуулахтай холбогдох, гэрлэгсэд, эцэг, эх, хүүхэд, гэр бүлийн бусад гишүүний хоорондох аминь болон эд хөрөнгийн харилцаа, хүүхэд үрчлүүлэх, үрчлэн авах, иргэдийг асрамжлах, харгалзан дэмжих, гэр бүлийн байдал, бүртгэлээс үүсэх зэрэг олон зарчмын гол харилцаануудыг зохицуулж байна.

Гэр бүлийн хуулийн нэг-

дүгээр хэсэгт гэр бүлийн хуулийн зорилго, зохицуулах харилцаа, гэр бүлийн үндэс, гэрлэснээ бүртгүүлэх үүрэг, эх үрний эрх ашгийг хамгаалах зэрэг зарчмын гол баримтлалуудыг заажээ.

Хуулийн 2 дугаар хэсэгт гэрлэгсдийн эрх үүрэг, гэрлэх нөхцөл, үндэс, гэрлэлтийг ёслол төгөлдөр явуулах зэрэг шинэ шинэ хэм хэмжээнүүдийг тогтоосон байна.

Хуулийн 3 дугаар хэсэгт гэр бүл, эцэг эх, хүүхдийн хувьд үүсэх төрөл бүрийн эрх үүргийг багтааж түүнтэй холбогдох асуудлыг тогтоожээ.

Гэрлэлтийг хүсэгчид гэрлэлтээ улсын бүртгэлд заавал бүртгүүлэх ёстой бөгөөд бүртгүүлсэн гэр бүлд энэ хуульд заасан эрх үүрэг үүсэх учрыг онцлон заасан байна.

Хуулийн 4 дүгээр хэсэгт гэр бүлийн байдлын тухай одоогийн журмыг үндсэнд нь хэвээр үлдээж зарим төрлийн харилцааг бүртгэх, сэргээх, гэрчилгээг шинэчлэн олгох талаар шинэ журам тогтоожээ.

Гэр бүлийн хуулийг биелүүлэх зааварт заахдаа: Улс, олон нийтийн байгууллага өөрийн харьяа ажилчин, албан хаагчид, иргэдийн дунд гэр бүлийн хуулийн биелэлтийг хангах, гэр бүлийн хууль, тогтоомжийг элдэв хэлбэрээр зөрчихгүй байлгах талаар ажил зохиож иргэний гэр бүлийн байдал бүртгэх байгууллагатай тогтмол харилцаж байх үүрэгтэй» гэжээ.

Гэр бүлийн хуулийн 2 дугаар зүйл (гэрлэх журам), 98 дугаар зүйлийн (хүүхэд төрснийг бүртгэх) заалтыг зөрчсөн этгээд 25—100 төгрөг хүртэл, 102 дугаар зүйлийг (шүүхийн шийдвэрээр гэрлэлт цуцлуулахыг бүртгэх заалтыг) зөрчсөн бол 100—200 хүртэл төгрөгөөр торгож байх болгожээ.

Гэр бүлийн хууль тогтоомжийг гүнзгий судлах нь иргэн бүрийн үүрэг бөгөөд өөрсдөө нарийн мэдэж хүндэтгэн биелүүлэх нь үр хүүхэд хойч үедээ үлдэг дууриалал болох юм.

Гэр бүлийнхэн дор дурдсан 3 чухал харилцааг эрхэмлэн биелүүлж байх нь чухал юм.

1. Гэрлэлтийн харилцаа: Энэ нь гэрлэгчид харилцан хоёр биений үнэнч сэтгэл, энэрэл итгэл хүндэтгэлийг ойлгож үнэнч шударга харилцааг илэрхийлж байх.

2. Гэр бүлийн харилцаа: Энэ нь тэгш эрхийн зарчим дээр харилцан бие биеэ хүндэтгэж ажил мэргэжлээ сонгож авах, гэр ахуйгаа хөтлөх, бусадтай харилцах зэрэг өргөн асуудал хамарсан чухал харилцаа юм.

3. Эцэг эх, үр хүүхэд, төрөл төрөгсдийн хоорондын харилцааны асуудал: Энэ нь эцэг эх, үр хүүхдээ асран тэтгэж, өсгөн бойжуулах тэдгээрийн хоорондын хүүхэд үрчлэх, эд хөрөнгө, тэжээн тэтгэх болон ахуй амьдралыг зохион байгуулах зэрэг нарийн зүйлүүд хамаарагдана.

Эдгээр 3 харилцааг ёс суртахууны коммунист зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэх нь чухал байна.

Г.НЯМБУУ

„СПОРТ—74“ УРАЛДААНЫ БОЛЗОЛ

МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж, МБТСЭ-ийн Төв Зөвлөлөөс зарласан «Спорт—74» уралдааныг эрчимжүүлэх зорилгоор биений тамир спортын «Урлаг» нийгэмлэгийн анхан шатны байгууллагуудын дотоод ажил, спортын сургалт дасгалжуулалт, биений тамир спортын сурталчилгаа, нийтийн биений тамирын хөдөлгөөнийг өрнүүлэх зорилгоор доорхи болзлыг зарлаж байна.

Үүнд:

1. Биений тамир спортын эвлэлийн үүрийн дотоод ажлыг зааварчилгааны дагуу төрөлжүүлж, тогтмолжуулан сайжруулах.

2. Биений тамирын үүрт өгөгдсөн гишүүдийн эгнээний өсөлт, зэрэгтэй тамирчинд, шүүгчид бэлтгэх төлөвлөгөө «Спортын мэдээ» сонинны захирлын хяналтын төлөвлөгөө, МБТСЭ-ийн гишүүдийн татварын хяналтын төлөвлөгөөг 100 ба түүнээс дээш хувинар жигд биелүүлэх.

Татварт хурааж авсан мөнгийг зохих дансанд 1974 оны 6 дугаар сарын 1-ний дотор оруулж тоо-

цоог дуусгасан байна.

3. Спортын байршилд тогтоосон 5-аас доошгүй төрөлд сонгон суралцах секцийг хичээллүүлж тогтмолжуулсан байна.

4. Мөн байршилд заагдсан спортын төрлүүдээр төрийн байгууллагын аварга шалгаруулж, тэмцээнд баг тамирчдаа бэлтгэж оролцуулсан байна.

5. Биений тамир спортыг сурталчилсан тойрон аялал, идэвхтэй амралт, зугаалгыг спортын сурталчилгаа, уралдаан тэмцээн, аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх ажлуудтай холбож 4-өөс доошгүй удаа зохион байгуулж явуулсан байхын дээр спортын сэдэвт АСК-ыг 2 удаа явуулсан байна. Дээрхи ажлуудын үндсэн материалыг сайн бүрдүүлэх бөгөөд энэ ажлын үр дүнд биений тамир спортын ач холбогдлыг нийт малчид, залуучууд бүрэн ойлгосон байх.

6. Эмнэг хангал адуу, тэмээг уналга эдэлгээнд сургах болзолт уралдаан зарлаж дүгнэсэн байна.

Сумдын бүх эмнэг хангалын 70-аас доошгүй хувийг уналга эдэлгээнд

сургаж, аж ахуйн ажилд ашиглаж үр дүнг тооцсон байна.

7. Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн гимнасткийн тогтмолжуулсан байна.

Болзолт уралдааны биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 10-ны дотор нийгэмлэгт ирүүлнэ. Болзолт 11 дүгээр сарын 25-ны дотор газар дээр нь нийгэмлэгийн төлөөлөгч шалгана.

Уралдааны шагнал

Болзлыг бүрэн биелүүлсэн биений тамирын үүр 1-ийг шалгаруулж 1 дүгээр байр эзлүүлж, биений тамир спортын «Урлаг» нийгэмлэгийн 1 дүгээр зэргийн диплом, 900 төгрөг, 2 дугаар байрт 1-ийг шалгаруулж 2 дугаар зэргийн диплом, 700 төгрөгөөр, 3 дугаар байрт орсон биений тамирын үүр 1-ийг 3 дугаар зэргийн диплом, 500 төгрөгөөр шагнана.

1, 2, 3 дугаар байр эзэлсэн сумдын биений тамирын үүрийн дарга, биений тамирын багш, идэвхтэн нарыг шалгаруулж нийгэмлэгийн диплом, сайшаалын үнэмлэх, баярын бичиг, үнэ бүхий зүйлээр урамшуулна.

дакцаас ирүүлэх олон сонирхолтой материал нийтлэх болно.

Тус сонинны редакци тэргүүн туршлагыг аргачлан нийтлэж, цохон эзэмшүүлж, үр дүнг тухай бүр тооцон нийтлэхээр төлөвлөж байгаагаас гадна кино дэлгэц, урлагийн тайзнаа гэсэн булан нээж, шинэ кино, жүжгийн тайлбар үе үе нийтлэхийн хамт уран зохиолын нуур гаргалтыг олшруулж орчуулгын зохиол, залуу уран бүтээлчдийн бүтээлээс өргөн нийтлэнэ. Нямдээ хүндэт уншигчид та бүхэн «Анхдугаар таван жил» сонинноо өргөнөөр захиалан уншигчдаа уу? СОНИНЫ РЕДАКЦИ

Буйлс цэцэглэж байхад...

Манай кино театрын дэлгэцнээ «Буйлс цэцэглэж байхад» гэдэг шинэ кино гарч байна.

Уг кинонд сурагчийн нэг жолоодож Лексог ширээнээс насанд хүрэгчдийн амьдралд шилжин орох гэж байгаа охид, хөвгүүдийн зан төрх, тэдний үерхэл нөхөрлөлийн тухай өгүүлэгдэх ба уг киног «Грузия» кино үйлдвэрт бүтээжээ. Киноны үйл явдал хавар буйлс мод цэцэглэх үед болно. Хатуна охин ангийнхаа Зурабт сэтгэлтэй болов. Гэтэл Зурабын даруу биш, хөнгөн зан Хатуныг маш их гомдоодог. Энэ байдлыг мэдсэн тэдний найз Лексо, Хатуна, Зураб хоёрыг эвлэрүүлэхийн тулд Зурабыг, Хатуны өмнө очиж буруугаа хүлээхийг шаардана.

Эцгийн «Волга» маши-

Н.ГАЛБАДРАХ



Киноны гол дүр: Хатуна, Зураб

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

Хүндэт уншигчид аа!

«Анхдугаар таван жил» сонинны энэ оны сүүлчийн хавас жилийн дугааруудад «Хөдөлмөрчдийн хууль зүйн мэдлэгт» гэсэн буланг тогтмол ажиллуулахаас гадна уншигчдийн хүсэлтээр «Орос хэлний эхнээг хичээл», «Асуулт бүхэнд хариулна» гэсэн булан шинээр нээж, уншигчдийн сонирхсон асууллагуудад хариу гч нийтлэнэ. Мөн тус аймагтай шөдийн холбоо тогтоосон ЗСБНХОУ-ын Курган мужийн «Советское зауралье» сонинны ре-